

**МОНГОЛЫН
ХӨДӨЛМӨРЧДИЙН СОЁЛ,
БОЛОВСРОЛЫГ
ДЭЭШЛҮҮЛСЭН АРГА
ЗАМЫН ТУХАЙ**

Үрцэцэг

Хөдөлмөрчдийн соёл, боловсролыг байнга дээшлүүлэх нь нэгэн улс орон ба үндэстний хөгжиж мандах зайлшгүй шаардлага мөн. Өргөн уудам нутаг дэвсгэртэй, цөөн хүн амтай Монгол улсын хувьд хөдөлмөрчдийн соёл, боловсролыг хэрхэн дээшлүүлэх вэ гэдэг асуудал нэн чухал ач холбогдолтой нь дамжиггүй. Монгол улс нь дэлхийн хамгийн хоцронгуй газрын нэг байсан бол өдгөө алхам алхмаар аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон руу шилжиж байгаа улс орон болон хөгжиж байна. Ийнхүү хөгжсөн нь тус орны нийгмийн байгуулал, эдийн засгийн бодлого, гадаадын тусламж зэрэг хүчин зүйлүүдээс гадна боловсролыг эрхэмд үзэн, хөдөлмөрчдийн соёл, боловсролыг байнга дээшлүүлж байсантай шууд холбоотой юм.

70-аад жилийн өмнө Монголын ард түмэн хар, шар феодалуудын дарлалд туйлын хоцрогдмол бөглүү байдалд байсан билээ. Гэтэл өнөөдөр Монголын Хөдөлмөрчид орчин үеийн соёл боловсрол, шинжлэх ухаан, техникийн мэргэжлийг эзэмшсэн, ажилчин, малчин, сэхээтэн болж, улс орныхоо нийгмийн хөгжлийг ахиулагч хөдөлгөгч хүчин болсон байна. Энэхүү байдлаас үүдэн, тус орны хөдөлмөрчдийн соёл, боловсролыг дээшлүүлсэн туршлагыг судлууртай байна гэж үзвэл зохино.

Монголын хөдөлмөрчдийн соёл, боловсролыг дээшлүүлсэн гол арга замын талаар өгүүлье.

1. Сургуулийн боловсролыг эрчимтэй хөгжүүлж, соёл, боловсролтой хөдөлмөрчдийг бэлтгэсэн нь. Боловсролыг эрчимтэй хөгжүүлж, хөдөлмөрчдийн соёл, мэргэжлийг нийтээр дээшлүүлэх нь монголын нам, засгийн тууштай бодлого мөн. 1921 онд анхны бага сургууль байгуулсан цагаас хойш монголын нам, засгаас боловсролыг хөгжүүлэх чиглэлийг тууштай баримталж, соёл, боловсролтой хөдөлмөрчдийг бэлтгэхийн төлөө цуцалтгүй чармайн ажилласан. 70-аад жилийн турш тус орон боловсролын салбарт оруулах хөрөнгийг тасралтгүй нэмэгдүүлж, нийгмийн бүхий л хүчинд тулгуурлан төрөл бүрийн сургууль байгуулах чиглэлийг баримталж, бага, дунд сургуулийн боловсролыг нийтээр олгон, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилган, бүх хөдөлмөрчид нь ямар нэгэн боловсролтой болжээ. Үүний хамт дээд ба тусгай, техник мэргэжлийн сургуулийг хөгжүүлж, техник мэргэжлийн ажилтан, мэргэжилтэн, дадлага туршлагатай хүмүүсийг бэлтгэж, хөдөлмөрчдийн шинжлэх ухаан, техникийн мэдлэгийн түвшинг тасралтгүй дээшлүүлэв.

Одоо монголын 16-49 насны хүмүүсийн 90 гаруй хувь нь багаас дээш боловсролтой болжээ. УААА-д ажиллагсдын 60-аас дээш хувь нь дээд ба тусгай дунд боловсролтой юм. Түүний дотор тусгай мэргэжлийн ажилтнуудын 50-иас дээш хувь нь тусгай дунд боловсролтой, 40-өөс дээш хувь нь дээд боловсролтой аж. Үйлдвэр, аж ахуйн газар,

САА, ХАА-н нэгдлийн удирдах ажилтнууд үндсэндээ бүгд дээд боловсролтой болжээ.

Үйлдвэр, аж ахуйн газрын ажилчдын 60-аас дээш хувь нь дундаас дээш боловсролтой юм. Тэдгээрийн 1/3 нь техник мэргэжлийн сургууль төгсөгчид бөгөөд 70-аас дээш хувь нь мэргэжлийн зэрэгтэй ажээ. ХАА-н салбарт дээд боловсролтой 6 мянга гаруй мэргэжилтэн, дунд боловсролтой 10 мянга гаруй тусгай мэргэжлийн ажилтан бий. Залуу малчдын дийлэнх олонхи нь ерөнхий боловсролын сургууль төгсжээ. Дээрх байдлаас үзэхэл, монголын хөдөлмөрчид нэлээн өндөр хэмжээний соёл, боловсрол бүхий болох нь илэрхий байна.

Хар, шар, феодалуудад урт хугацаагаар дарлагдаж, хамгийн хоцронгуй орны хуучин буурь дээр улсаа байгуулсан гэдгийг бид сайн мэдэх юм. Ийм улс хэдэн аравхан жилийн дотор бичиг үсэг үл мэдэх явдлыг арилган, соёл, боловсролтой хөдөлмөрчдийг бэлтгэсэн нь үнэхээр гайхамшигтай юм.

Сургуулийг өргөтгөж, сурагчдын тоог нэмэгдүүлэх явдал бол боловсролыг хөгжүүлж, хөдөлмөрчдийн оюуны түвшинг дээшлүүлэх гол арга замын нэг юм. Монголын бүх шатны сургуулийн тоо 1921 онд нэгхэн бага сургууль байсан бол 1988 онд 1029 хүртэл нэмэгджээ. Түүний дотор дээд сургууль 8, тусгай мэргэжлийн дунд сургууль 29, техник мэргэжлийн сургууль 43, ерөнхий боловсролын өдрийн сургууль 607, Хөдөлмөрчдийн ерөнхий боловсролын сургууль 342 байна. Эдгээр сургуульд суралцагчдын тоо 500 гаруй мянгад хүрсэн нь хүн амын бараг 27%-ийг эзлэх болжээ. Бүх шатны сургуулийн сурагчдын тоо 1960 онд 1940 оныхоос 5 дахин, 1988 онд 1960 оныхоос бараг 4 дахин нэмэгджээ.

Монголд жил бүр бүх шатны сургууль төгсөгчдөөр УААА-н салбаруудын ажиллах хүчийг сэлбэн бэхжүүлж байдаг учир хөдөлмөрчдийн соёл, боловсролын бүтцийг ямагт шинэчилж байдаг байна. Жишээлбэл, тус улсын ХААДС сүүлийн 15 жилд малын эмч, зоотехникч, агрономич, инженер, эдийн засагч зэрэг мэргэжлээр 4,5 мянган ажилтныг бэлтгэсэн байна.

Боловсролд гаргах зардлыг ямагт нэмэгдүүлж, төрөл бүрийн арга замаар хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг өргөтгөх нь боловсролыг хөгжүүлэх гол арга хэмжээний нэг болно. 60-аад оноос хойш, тус орны нийгэм, соёлын арга хэмжээнд оруулах хөрөнгө оруулалтын өсөлт нь эдийн засгийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын өсөлтөөс түрүүлсэн хэвээр байв. Энэ талаар Монгол улс нь Америк, Япон зэрэг хөгжингүй орнуудтай адилавартай байна.

Тус орон боловсролыг хөгжүүлэхдээ үйлдвэрлэл, шинжлэх ухаан, техникийн хөгжлийн шаардлагыг харгалзан үзэж, боловсролын системээ өөрчлөн шинэчилж, сургалтын агуулгаа боловсронгуй болгож, үйлдвэрлэл ба сургалтыг хослуулсан болно. Монголын бүх шатны сургуулиудад хөдөлмөрийн болон мэргэжлийн дадлагын хичээл заадаг. Одоо сурагчид нийгмийн хөдөлмөрт оролцох ба мэргэжлийн дадлага хийх хугацаа нь өнгөрсөн үеийнхээс 2 дахин нэмэгджээ. Ийнхүү олон жилийн турш сургалтыг үйлдвэрлэл, хөдөлмөр, эрдэм шинжилгээний ажилтай хосолсноор бага, дунд сургуулийн сурагчид багаасаа хөдөлмөрийг эрхэмлэх заншилтай болж, дээд, тусгай мэргэжлийн дунд сургуулийн оюутан, сурагчид нь эрдэм шинжилгээний болон мэргэжлийн дадлагатай болдог тул ажилд орсныхоо дараа богино хугацаанд хурдан дадлагажиж, үр бүтээлтэй ажиллах чадвартай болдог байна.

2. Ажлын байран дахь боловсролыг олон хэлбэрээр хөгжүүлсэн нь. Ажлын байран дахь боловсролыг хөгжүүлж, хөдөлмөрчдийн мэдлэгийг ямагт шинэчлэх явдал бол Монголын хөдөлмөрчдийг соёл, боловсрол, оюуны чадавхийг дээшлүүлэх чухал арга зам мөн. Хөдөлмөрчдийг ажлын байранд нь сургах маш олон хэлбэр байдаг. Тухайлбал, насанд хүрэгчдийн ерөнхий боловсрол, хөдөлмөрчдийн дээд ба тусгай дунд мэргэжлийн боловсрол зэрэг хэлбэр байна.

Хөдөлмөрчдийн ерөнхий боловсрол бол монголын боловсролын системийн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. 60-аад оноос эхлэн хөдөлмөрчдийн ерөнхий боловсролыг хөгжүүлэхийн тул олон төрлийн сургууль байгуулсан юм. Жишээлбэл, хөдөө аж ахуйн онцлогт зохицсон улирлын сургууль, түр сургууль, үйлдвэр, аж ахуйн газрын ерөнхий боловсролын сургууль, оройн сургууль г. м. Ажиллаж байгаа хүмүүст дээд ба тусгай мэргэжлийн дунд боловсрол эзэмшүүлэх ажлыг голдуу оройн ба эчнээ сургалтаар хийдэг. Монгол эчнээгээр суралцагчдын насыг хязгаарладаггүй юм. Орой ба эчнээгээр суралцагчид бүх оюутны 20-иос дээш хувийг эзэлж байна. Тэд ердийн оюутнуудаас нэг жил илүү суралцдаг ба энэ нь ажлаасаа хөндийрөлгүй сургуулийн хичээлийг гүйцэд сурахад дөхөмтэй ажээ. Техник мэргэжлийн сургууль, тусгай мэргэжлийн дунд сургууль төгсөөд мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан болон бүрэн дунд сургууль төгсөөд жил хагасаас илүү ажилласан онц бүтээлтэй хүмүүсийг эн тэргүүн дээд сургуульд элсүүлдэг юм.

ТМС болон ажил дээр нь сургах хоёр хэлбэрээр УААА-н ажилчдыг бэлтгэдэг. ТМС-д ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг авахаас гадна тодорхой мэргэжил эзэмшээгүй ажилчдыг 6 сараас 1 жил хагасын хугацаагаар хүлээн авч сургадаг. Сурагчид сургуульд байхдаа үйлдвэрлэлийн ба мэргэжлийн дадлага хийж, 70%-ийн цалин авдаг байна.

70-аад он хүртэл Монголд голдуу техникийн дугуйлан байгуулах хэлбэрээр үйлдвэр, аж ахуйн газрын ажилчдын мэргэжлийг дээшлүүлдэг байв. 1973 оноос техникийн дугуйланг 3 жилийн хугацаатай ажилчдын мэргэжил дээшлүүлэх сургууль болгон өөрчилсөн болно. 1975 оноос Монголын засгийн газар бүх аж үйлдвэрийн газарт ажилчдын мэргэжил дээшлүүлэх сургууль байгуулах шийдвэр гаргасан. 80-аад оноос хойш монголд мэргэжилтэй ажилчин бэлтгэх нэгдсэн систем бий болж, нийт ажилчдад мэргэжлийн сургалтыг төлөвлөгөө системтэй заах боллоо.

Гадаадад мэргэжилтэй ажилчин бэлтгэх нь тус улсын хөдөлмөрчдийн техник мэргэжлийг дээшлүүлэх бас нэг арга зам болсон юм. 50 иад онд Монгол, Зөвлөлтийн засгийн газар хооронд үйлдвэрлэл ба мэргэжлийн сургалтаар хоёр орны техник мэргэжлийн ажилчин бэлтгэх хэлэлцээр байгуулснаас хойш Монголоос ерөнхий боловсролын сургууль төгсөгчид, залуу ажилчид, малчид ЗХУ болон бусад оронд олноор суралцах болжээ. Зохих хэмжээний мэргэжлийн суурь мэдлэгтэй хүмүүсийг явуулж, нарийн мэргэжлээр суралцуулдаг. Ингэснээр дотоодод дутагдаж байгаа мэргэжилтэнг бэлтгэж авдаг байна.

Сүүлийн 20 гаруй жилийн турш тус оронд гадаадын дэвшилт техник татан оруулж, ЗХУ болон бусад орнуудын шинжлэх ухаан, техникийн ололт амжилт, орчин үеийн үйлдвэрлэлийн арга хэлбэрийг нэвтрүүлж, улс орныхоо шинжлэх ухаан, техник, үйлдвэрлэлийн шинэчлэлтийг дээшлүүлснээр хөдөлмөрчдөд мэдлэг боловсролоо ахиулах нөхцөлийг хангаж өгчээ.

Хөдөлмөрчдийн соёл, боловсролын хэмжээг тасралтгүй дээшлүүлэх явдал нь Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн шаардлага төдийгүй дэлхийн техникийн хувьсгалын шаардлагад нийцэх юм. Одоо ид өрнөж буй техникийн шинэ хувьсгал бол дэлхийн хэмжээний «оюуны өрсөлдөөн», «мэдлэгийн хувьсгал» билээ. Эрдэм мэдлэг нэгэнт үйлдвэрлэх хүчин, өрсөлдөх хүчин боллоо гэж хөрөнгөтөн орны зарим эдийн засагч эрдэмтэд үздэг нь бодит байдалд нийцэж байна. Шинжлэх ухаан, техник түргэн хөгжиж буй өдгөө үед буурай хөгжилтэй орнууд урагшлан хөгжье гэвэл эрх биш үйлдвэрлэх хүчний шийдвэрлэх хүчин зүйл болох хөдөлмөрчдийн оюуны мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх хэрэгтэй юм.

Энэ үүднээс, Монгол орон 70-аад жилийн туршид соёл, боловсролыг эрхэмлэн хөгжүүлэх замаар хөдөлмөрчдийн мэдлэг боловсролыг ямагт дээшлүүлсэн туршлага нь хөгжиж буй буюу буурай хөгжилтэй орнуудад үлгэр болох нь дамжиггүй ээ.

Товчлон орчуулсан **С. Жаргалсайхан**
1990.5.27